



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 462

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, 2024 оны "Төрийн өмчийн зарим их сургуулийн талаар авах арга хэмжээний тухай" 207 дугаар тогтоол, Архангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2024 оны 13 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн балансад бүртгэлтэй, 17 нэрийн, нийт 4,971,195,902.63 (дөрвөн тэрбум есөн зуун далан нэгэн сая нэг зуун ерэн таван мянга есөн зуун хоёр төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 524,617,886.68 (таван зуун хорин дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга найман зуун наян зургаан төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Архангай аймгийн Орон нутгийн гарын дарга Х.Ганхуяг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор Б.Дамдиндорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3. Газар эзэмших эрх (32831 м.кв)-ийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нэр дээр шилжүүлэн авах, баталгаажуулах, үнэлж бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.4. Элэгдэж дууссан боловч цаашид зориулалтын дагуу ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭС ИЙН ДАРГА

Д.Нарангэрэл Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 0 дугаар сарын 16-ны өдрийн
№ дугаар тогтоолын хавсралт

АРХАНГАЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН БАЛАНСАД БҮРТГЭЛТЭЙ,
ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
	Барилга, байгууламж						
1	Нэгдсэн эмнэлэг	1979	м2	4846	1,322,760,053.96	55,115,002.20	1,267,645,051.76
2	Төрөхийн барилга	1994	м2	2758.37	2,123,184,772.85	114,152,637.48	2,009,032,135.37
3	Авто гражийн барилга	1979	м2	249.1	13,369,876.55	13,369,876.55	-
4	Хүүхдийн эмнэлэг	2014	м2	1295	525,238,476.58	84,965,047.86	440,273,428.72
5	Халдвартын эмнэлэг	2009	м2	807.84	596,493,444.03	50,472,521.88	546,020,922.15
6	Хөрөнгийн склад	1994	м2	125.9	3,778,268.81	670,337.58	3,107,931.23
7	Цайны газрын барилга	2003	м2	65	2,437,751.62	609,438.06	1,828,313.56
8	Мооргын барилга	2022	м2		247,248.00	185,436.00	61,812.00
9	Ариутгалын барилга	2018	м2	129.6	95,742,263.75	15,231,723.78	80,510,539.97
10	Авто машин бетон зогсоол	1979	м2	1144	12,359,216.00	12,359,216.00	-
11	Блокон хашаа	1979	м2	999	16,113,117.60	1,626,804.90	14,486,312.70
12	Галын байр	2022	м2		39,987.00	29,990.34	9,996.66
13	Бохирын шугам	1979	м2	642	59,145,803.64	6,378,469.02	52,767,334.62
14	Цахилгааны шугам	1979	м2	1908	32,005,457.51	3,451,569.00	28,553,888.51
15	Цэвэр болон халуун усны шугам	1979	м2	685	165,251,403.93	165,251,403.93	-
16	Төмөр хайс	2010	м2		2,343,320.80	234,332.10	2,108,988.70

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
17	Хайс хашаа	2022	м2		685,440.00	514,080.00	171,360.00
	НИЙТ ДҮН				4,971,195,902.63 (дөрвөн тэрбум есөн зуун далан нэгэн сая нэг зуун ерэн таван мянга есөн зуун хоёр төгрөг жаран гурван мөнгө)	524,617,886.68 (таван зуун хорин дөрвөн сая зургаан зуун арван долоон мянга найман зуун наян зургаан төгрөг жаран найман мөнгө)	4,446,578,015.95 (дөрвөн тэрбум дөрвөн зуун дөчин зургаан сая таван зуун далан найман мянга арван таван төгрөг ерэн таван мөнгө)